



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 19/30

Өвт

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.4, 46.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үнэлгээний хорооны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг үндэслэн Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх ажлыг “Батгэгээн хангай” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. “Батгэгээн хангай” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч (Б.Ууганчимэг)-т даалгасугай.

3. Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх хүүхдийн хоолны зардалд 81,998,000 (наян нэгэн сая есөн зуун ерэн найман мянган) төгрөгийг гэрээний дагуу санхүүжүүлэхийг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ц.Ганцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ